

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	9
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	12
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	15
5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	17
6. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө.....	19
7. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	21
8. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	21
9. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	22
10. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	24
11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	32
12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	34
13. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах	35

Зургийн жагсаалт

Зураг 1. Гаалийн хяналтын талбайн байршил.....	4
Зураг 2. Талбайн одоогийн харагдах байдал.....	4
Зураг 3. Ажилчдын кемп	5
Зураг 4. Гал тогооны харагдах байдал	5
Зураг 5. Оффис, доторх тохижилт	6
Зураг 6. Душ, угаалгын өрөө	6
Зураг 7. Гашуун сухайт-Тавантолгойн автозамаас алслах зай	7
Зураг 8. Ангилан ялгах хогийн савнууд	8

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Нөлөөллийн үнэлгээний систем.....	13
Хүснэгт 2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	17
Хүснэгт 3. Нөхөн сэргээлт, орчны тохижилтын төлөвлөгөө	19
Хүснэгт 4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	21
Хүснэгт 5. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	22
Хүснэгт 6. Төслийн үйл ажиллагааны явцад гарах хог хаягдлын хэмжээ	25
Хүснэгт 7. Төслийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлын ангилал	26
Хүснэгт 8. Хог хаягдлыг цуглуулах, түр хадгалах нөхцөлийг сайжруулах	27
Хүснэгт 9. Хог хаягдлыг зайлуулах	28
Хүснэгт 10. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	30
Хүснэгт 11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	33
Хүснэгт 12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх зардал.....	36

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“КАЙТЛ РАЙНЧ” ХХК нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан багийн нутаг дэвсгэрт Цагаан хад нэртэй газарт орших 10 га талбай бүхий газрыг Ханбогд сумын Засаг даргын 2021 оны А/9 тоот тушаалаар 15 жилийн хугацаатай, гаалийн хяналтын талбайн зориулалтаар эзэмшиж байна.

Гаалийн хяналтын талбай төслийг хэрэгжүүлэхэд тээврийн жолооч нар байрлан ажиллах кемп шаардлагатай болдог бөгөөд энэхүү эзэмшил газартаа Гаалийн хяналтын талбайн “Ажилчдын кемп, авто зогсоол” ажиллуулж байна. Энэхүү төслийн талбайд нүүрс буулгах, тээвэрлэх, зөөх ажил огтхон ч хийгдэхгүй, зөвхөн нүүрс тээвэрт явдаг автомашинуудын жолооч нар байрлаж, авто машинууд зогсох юм. Тус кемпед гаалийн хяналтын талбайд ажилладаг тогтмол 4-5 жолооч, ээлжээр 20 орчим жолооч нар байрладаг. Кемпед нийтдээ 10-н гэр, 3-н зөөврийн байшин байна.

Мөн тус талбайд “ЛХАС ТРАНС” ХХК-ийн хүнд даацын машинууд байрладаг. Одоогийн байдлаар 20 машин байрладаг. Авто машины засвар үйлчилгээг “Хайрхан авто Сервис” ХХК-аар хийлгэдэг байна.

2023 онд тус кемпийг худалдаж аван бэлтгэл ажил хийгдсэн бөгөөд 2024 онд үйл ажиллагаагаа тогтмол явуулах төлөвлөгөөтэй байна.

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр: “КАЙТЛ РАЙНЧ” ХХК

Хаяг: Улсын бүртгэлийн дугаар:1111013123


Регистрийн дугаар: 3634302

Өмнөговь аймаг, Даланзадгад, 5-р баг,
Зүүнсайхан 5, 29

Утас/факс: 99087158

Төслийн байршил

“Гаалийн хяналтын талбай” нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт Цагаан хад хэмээх газарт сумын төвөөс зүүн урагш 70 км, Гашуун Сухайтын хилийн боомтоос 30 км-т байрлана.



Зураг 1. Гаалийн хяналтын талбайн байршил



Зураг 2. Талбайн одоогийн харагдах байдал



Зураг 3. Ажилчдын кемп



Гал тогооны хэсэг

Зураг 4. Гал тогооны харагдах байдал



Зураг 5. Оффис, доторх тохижилт



Зураг 6. Душ, угаалгын өрөө

Дэд бүтэц

Усан хангамж: Зөөврөөр хангаж байна.

Цахилгаан, дулаан хангамж: Талбайн гэрэлтүүлэг болон дотоодын хэрэгцээг эхний ээлжинд дизель цахилгаан үүсгүүрээр хангаж байгаа бөгөөд цаашдаа Цагаанхад дэд станцаас цахилгааны агаарын шугам татаж хэрэгцээгээ хангана.

Зам: Гаалийн хяналтын талбайн ажилчдын кемп нь Эрдэнэс таван толгой - Гашуун сухайтын боомтын нүүрсний тээврийн замаас зүүн тийш 1.0 км зайтай байрлана.



Зураг 7. Гашуун сухайт-Тавантолгойн автозамаас алслах зай

Хатуу хог хаягдал

Төслийн үйл ажиллагаанаас ахуйн гаралтай хог хаягдал гарна. Хатуу хог хаягдлын тухай хуулийн 8-р зүйлийн 8.4.3-т заасны дагуу “Ханбогд хот тохижилт”-ний газартай байгуулсан.

Ажилчдын гал тогоо болон кемпийн гадна талд ангилан ялгах хогийн савнуудыг байршуулсан.





Зураг 8. Ангилан ялгах хогийн савнууд

Шингэн хог хаягдал

Төслийн үйл ажиллагаанаас гарах бохир шингэн хаягдлаа бохирын цооногт хуримтлуулан Хандизель ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулан соруулдаг.

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Физик газарзүйн нөхцөл

Төсөл хэрэгжих талбай нь физик газарзүйн мужлалын хувьд Говийн их мужийн Дорнод говийн мужийн Сулинхээр-Замын-Үүдийн талархаг газрын мужид харьяалагдана. Газарзүйн мужлалаар цөлийн ландшафттай говийн мужид хамаарах бөгөөд газарзүйн хэлбэр, гадаргуугийн хэв шинжээр Э.М.Мурзаев цав толгод, ухаа гүвээт талын хэв шинжид багтаан үзжээ. Хуурай сайраар хэрчигдсэн, үнэмлэхүй өндөр нь 900-1100 м, орой хяр нь хавтгай ба бөмбөгөр хэлбэртэй, хажуу нь налуу хад асга багатай цав толгод болон ухаа гүвээт тал зонхилдог. Ханбогд сум нь Монголын говь цөлийн бүсийн өмнөд хэсэгт байрладаг ба Ханбогд уулын орчимд орших говийн намхан толгодоос тогтдог. Говийн бүсдээ харьцангуй өндөрт тооцогдох уулуудтай ба үүнд Ханбогд уул (д.т.д 1350 м), Бумбат задгайн хяр (д.т.д 1233.3 м), Жавхлант уул 1295 м (д.т.д), Далайн Дуулга (д.т.д 1240 м) зэрэг уулс орно.

Уур амьсгал

Төслийн талбай орчмын газар нутаг нь эх газрын эрс тэс уур амьсгалтай бөгөөд гандуу дулаан зунтай, хүйтэн өвөлтэй мужид хамаарагдах бөгөөд Монгол Улсын хамгийн дулаан цэгт тооцогддог газар нутаг юм.

Говийн хахир хатуу уур амьсгалын нөхцөл байдал нь сумын нийгэм, эдийн засагт ихээхэн хамааралтай. Температурын хазайц хэтэрхий эрс тэс, өвөлдөө хамгийн бага температур -34°C -ээс бага, зуны улиралд ихэвчлэн 40°C -аас давж хална. Ханбогд суманд өвөлдөө Монгол орны хойд хэсгийн нутагтай харьцуулахад арай богино өдрүүдтэй. Оюутолгойн ордын орчмын задгай тал хээр, хөндий, нам дор газар нь өвөлдөө хүйтэн, хур тунадас багатайн зэрэгцээ салхи ихтэй байдаг. Говьд их хуурайшилтай байдгаас тус газар нутагт цас бага унана. Өвлийн цагт агаарын температур -5°C -аас -34°C хооронд хэлбэлзэнэ. Хамгийн хүйтэн сар болох нэгдүгээр сард дундаж температур -12°C , үнэмлэхүй бага температур -34°C хүрнэ. Цас унавал ихэнхдээ 5 см зузаантай байна.

Ханбогд сумын чийг дулааны горим нь Монгол орны бусад бүсээс чийг бага, дулааны нөөц ихтэйгээрээ онцлог юм. Уул нуруудаар хүрээлэгдсэний улмаас чийглэг агаар орж ирэх нь ховор, үүнээс гадна салхины хурд ихтэй, үүний улмаас ховор ургамлын бүрхэвч сийрэг, газрын гадарга өдрийн цагт эрс халж, шөнө хөрч, температурын хоногийн хэлбэлзэл ихтэй. Тус сум нь уур амьсгалын хувьд хуурай мужид хамаардаг, хуурайдуу халуун зунтай, салхи шуурга ихтэй. Хавар зуны улиралд халуун салхитай, шороон шуурга ихтэй. Жилийн дундаж температур олон жилийн дунджаас илүү нэмэгдэж, хуурай болон хагас хуурай цаг агаар зонхилох болсон.

Ханбогд сумын агаарын чанар болон ургамлан бүрхэвчид нөлөөлж буй гол хүчин зүйл нь салхи юм. Түүнчлэн салхиар үлээгдсэн тоос шороо газрын гадарга, хэв маягийг өөрчилж, улмаар говийн бүс нутгийн цөлжилтийн хэмжээнд хувь нэмэр оруулж байна. Өвөлдөө (I дүгээр сар) салхины дундаж хурд Ханбогд суманд 1.7-4.4 м/сек байна. Хавар IV дүгээр сард салхины дундаж хурд 3.9-5.6 м/сек байна. Тус сум нь зөөлөн салхи (1.0-5.99 м/сек) давамгайлах боловч, арай хүчтэй салхи тохиолдох нь бий. Энэ үед салхины хурд 6.0-11.99 м/сек хүрнэ. Салхины хурд 12.0-19.99 м/сек байх үе 3, 4, 6, 9, 10 дугаар саруудад тохиолдоно.

Хөрсний өнгөн давхаргын жилийн дундаж температур 8.8°C байдаг ба зөвхөн өвлийн саруудад тэг градусаас доошилдог байна. 11 дүгээр сараас 2 дугаар сар хүртэл хөрсний дундаж температур -3.6°C -аас -13.2°C хүртэл буурдаг ба 3 дугаар сараас 10 дугаар сар хүртэлх хугацаанд $+0.3^{\circ}\text{C}$ -аас $+29^{\circ}\text{C}$ хүрдэг. Зуны их халуун саруудад хөрсний гадаргуугийн температур $+65^{\circ}\text{C}$ хүрдэг. Өвлийн цасан бүрхүүлтэй, хүйтэн өдрүүдэд хөрсөн дээр хамгийн бага температур -37°C хүрдэг.

Гадаргын болон гүний ус

Ус зүйн сүлжээний хувьд Төв Азийн гадагш урсгалгүй ай савд багтана. Судалгааны бүс нутаг нь хур тунадас багатай хуурай уур амьсгал бүхий нутаг дэвсгэрт орших тул гадаргын усны сүлжээ хөгжөөгүй, байнгын урсац бүхий гол мөрөн байхгүй. Ихээхэн хур борооноос үүдэн урсах түр зуурын сайр, жижиг хэмжээний нуур тойром үүсдэг онцлогтой бүс нутаг юм. Тухайн жил, улирлын цаг уур, хур тунадасны хэмжээнээс хамаарч усны горим ихээхэн хувьсамтгай буюу зарим газраа гандаж ширгэдэг онцлогтой.

Сумын хэмжээнд нийтдээ 365 худаг, өрөмдмөл 8, богино яндант 12, энгийн худаг 340, инженерийн хийцтэй худаг 2438, гар худаг 78, рашаан булаг 44 байна. Тухайн сумын хэмжээнд 67 голын эх үүсвэртэй байна. Үүнээс 69.0 хувь нь гүехэн гар худаг, 80.0 хувь нь 2 м хүрэхгүй гүнтэй, 21.0 хувь нь гүний худаг, 85.0 хувь нь цоожтой. Устай 22 булаг, ус багатай 14, ширгэсэн 20 гаруй булаг байна. Жавхлант, Гавилууд багуудад худгийн ундарга удаан, тогтоол ус, задгай ус ширгэсэн, Гавилуудад ажиллагаатай худаг байхгүй болсон байна. Баян, Номгон багуудад бэлчээр сайтай газруудад худаг хангалтгүй, өндөрлөг газруудад ус хомс байна. Халив-Дугатын голдирлыг өөрчилснөөс болж хэд хэдэн усны голдирол өөрчлөгдөж, бэлчээрийн талхагдалд нөлөө үзүүлж байна. Иймээс цаашид тухайн голын голдирлын бүрэн бүтэн байдлыг сайжруулах хэрэгтэй.

Ургамлан нөмрөг

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт Цагаан хад нэртэй газарт байрлах судалгааны талбай нь ургамал газарзүйн мужлалаар Сахар-Говь цөлийн их мужийн тал, талархуу газрын Өлгий хийд – Галбын говийн нутагт оршино. Физик газарзүйн мужлалаар Ханбогд сумын нутгийн ургамлын аймгийн хувьд баруун хойд хэсэг нь

Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт үлдсэн ихэнх хэсэг нь Алашаа говийн цөлийн тойрогт хамаарагдана.

Амьтны аймгийн төлөв байдал

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт хамаарах авто зогсоол, кемпийн талбай нь амьтны газарзүйн мужлалын хувьд Умард говийн болон Алтайн өвөр говийн тойрогт хамаарах (А.Г.Банников 1954) бөгөөд говь цөлийн амьтад тэргүүлэх бөгөөд мэрэгчдээс чичүүл, сохор оготно, савагдаахай, загийн шар чичүүл, говийн алаг даага, бор зусаг, туурайтнаас хар сүүлт, хулан, янгир, аргаль зонхилох ажээ. Хулан адуу, хар сүүлт зэрэг талын туруутан амьтдын томоохон сүргүүд байсан боловч нүүрс тээврийн автомашин, уул уурхайн зам тээвэр, хөл хөдөлгөөний улмаас Дорноговь аймгийн нутаг руу дайжсан. Гэвч энэ орчинд дэлхийн хэмжээнд ховорт тооцогддог Жороо тоодог – Houbara Bustard (*Chlamudotis undulata*) амьдардаг. Мөн Хулан жороо – Mongolian Ground Jay (*Podoces hendersoni*), Загийн бор шувуу – Saxaul Sparrow (*Passer ammodendri*) элбэг байдаг.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Аливаа төслийн байгаль орчинд үзүүлэх болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг зөв оновчтой тогтоох нь байгальд ихээхэн хэмжээний хохирол учруулан, эвдрэл доройтолд орохоос сэргийлэн улмаар хүрээлэн буй орчныг хамгаалах чухал арга хэмжээ юм.

ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

Төсөл хэрэгжих талбай нь Монгол улсын хилийн бүсэд нутагт байрлах тул тоос шороо дэгдэхээс хамгаалах, олон салаа зам гаргах зэргээр хөрсний эвдрэлийг ихэсгэхгүй байх шаардлагатай болно. Онц аюултай хүчтэй салхи, уруйн үер (хүчтэй аадар борооны дараах) зэрэг аюулт үзэгдэлд нэрвэгдэж болох талтай.

Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой асуудал

Барилга байгууламж барих болон ачиж буулгах талбайн аюулгүй ажиллагаатай холбоотой асуудал

Гаалийн хяналтын талбайн ажилчдын кемп нь жилийн турш зогсолтгүй үйл ажиллагаа явуулна. Нүүрс тээвэрлэлт байнга хийгдэх тул кемпэд ажилчид байнгын байрлана. Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад элэгдэж эвдрэлд орсон талбайн тохижилт, техникийн нөлөөллөөс хамгаалсан хатуу хучилт, салхины хаалт зэргийг хийж тоосжилт бууруулах нөхцөлийг хангах нь зүйтэй юм.

Төслийн нийт талбайн 60 хувийг хатуу хучилттай болгох бөгөөд энэхүү ажлын 5 жилийн хугацаанд үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Түлш шатахуун, шатах тослох материалыг ашиглах явцад осол аваараас сэргийлэх, аюулгүй ажиллагааны дүрмийг баримталж байх шаардлагатай болно. Мөн хог хаягдлын ангилсан стандартын шаардлага хангасан цэг байгуулах, бохир усыг дахин ашиглах, ариутгах, цэвэрлэх зэрэг ажлыг судалж нэвтрүүлэн үлгэр жишээ байх хэрэгтэй. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг мөрдөж ажиллах шаардлагатай.

Нөлөөллийг үнэлэх арга зүй. Нөлөөллийн үнэлгээг дараах аргыг ашиглан хийж гүйцэтгэв:

Нөлөөллийн чанар нь тухайн нөлөөллийн онцлогоос хамааран нөлөөллийн утга нь эерэг, сөрөг эсвэл саармаг байж болно (жишээ нь чухал ач холбогдол бүхий төрөл зүйлийн амьдрах орчин сайжирсан нь эерэг гэдэг ангилалд орох бол амьдрах орчин нь алдагдвал сөрөг гэдэг ангилалд орно).

Нөлөөллийн эрчим нь анализ буюу хэмжилтэд (жишээ нь бэлчээрийн талбайн хэмжээ, стандарт түвшинтэй харьцуулсан усны дээжинд агуулагдах хүнд

металлын агууламж зэрэг) гарсан өөрчлөлтийн хэмжээ бөгөөд нөлөөлөл байхгүй, бага, дунд зэрэг, их гэсэн ангиллуудтай байна.

Үргэлжлэх хугацаа нь байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийн үргэлжлэх хугацааг хэлнэ. Жишээ нь түр зуурын (1 жилээс доош хугацаатай), богино хугацааны (1-5 жил), дунд хугацааны (5-15 жил), урт хугацааны (15 жилээс дээш хугацаатай бөгөөд төсөл хаалт хүртэл үргэлжлэх) эсвэл байнгын нөлөөлөл гэх мэт.

Хамрах хүрээ/Нөлөөллийн бүс гэдэг нь тухайн нөлөөлөлд өртөх газрын хэмжээ цар хүрээг хэлэх бөгөөд тухайн орчны, орон нутгийн, бүс нутгийн, үндэсний хэмжээний, олон улсын хэмжээний гэх зэргээр ангилагдана.

Нөлөөлөл үүсэх магадлал гэдэг нь тухайн нөлөөлөл үүсэж бий болох магадлалын зэргийг тодорхойлж буй бөгөөд магадлал байхгүй (үүсэх магадлал нь 5%-аас бага), магадлал багатай (5-40%-ийн магадлалтай), магадлалтай (40-60%-ийн магадлалтай), магадлал өндөртэй (60-90%-ийн магадлалтай), гарцаагүй (магадлал нь 90%-аас дээш) гэх зэргээр ангилна.

Нөлөөллийн зэрэглэл гэдгийг мэргэжилтнүүд доорх хүснэгтэд үзүүлсэн оноо өгөх системийг ашиглан тодорхойлдог зүйл юм.

Хүснэгт 1. Нөлөөллийн үнэлгээний систем

Нөлөөллийн эрчим	Үргэлжлэх хугацаа	Хамрах хүрээ	Магадлал
10 - Маш их	5 – Байнгын (30- дээш жил)	5 - Олон улсын хэмжээнд	5 - Гарцаагүй
8 - Их	4 - Урт хугацааны (15-30 жил)	4 - Үндэсний хэмжээнд	4 - Өндөр магадлалтай
6 - Дунд	3 - Дунд хугацааны (5-15 жил)	3 - Бүс нутгийн хэмжээнд	3 - Дунд магадлалтай
4 - Бага	2 - Богино хугацааны (0-5 жил)	2 - Орон нутгийн хэмжээнд	2 - Бага магадлалтай
2 - Маш бага	1 - Түр зуурын	1 - Тухайн орчны хэмжээнд	1 - Тохиолдохгүй
0 - Нөлөөлөлгүй			
Хамгийн өндөр оноо 25 болох бөгөөд түүнийг 100% гэж үзвэл >75% Нөлөөллийн зэрэглэл өндөр 30%- 75% Нөлөөллийн зэрэглэл дунд <30% Нөлөөллийн зэрэглэл бага байх болно			

Нөлөөлөл тус бүрд эдгээр хүчин зүйлүүдийг эрэмбэлсний дараагаар үүсэх магадлал ба хор уршиг гэсэн 2 зүйлийн зэрэглэлийг доорх томъёог ашиглан тооцно:

$$\text{Оноо} = \text{Эрчим} + \text{Үргэлжлэх хугацаа} + \text{Хамрах хүрээ} + \text{Магадлал}$$

Онооны зэрэглэлийн хамгийн их утга нь 100%-тай тэнцүү байна. Байгаль орчны боломжит нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээтэй уялдуулан Их, Дунд зэрэг, Бага гэж дараах байдлаар зэрэглэн ангилна.

>75%	БО-нд нөлөөлөх зэрэглэл өндөр (Н) байгааг илтгэх	Энэ тохиолдолд ямар бууруулах арга хэмжээ байж болох вэ гэдгээс үл хамааран энэ нь төслийг эхлүүлэх эсэх талаар шийдвэр гаргахад нөлөөлнө.
30-75%	БО-нд үзүүлэх нөлөөлөл Дунд зэрэг (М) байгааг илтгэх	Бууруулах арга хэмжээ төлөвлөхгүй л бол энэ нь төслийг эхлүүлэх шийдвэрт нөлөөлнө. Дунд зэрэглэлийн нөлөөлөл нь менежментийн төлөвлөгөө гаргахыг зайлшгүй шаарддаг.
<30%	БО-нд үзүүлэх нөлөөллийн зэрэглэл Бага (L) байгааг илтгэх	Төслийг эхлүүлэх эсэх талаарх шийдвэрт нөлөө үзүүлэхгүй. Маш бага нөлөөлөл нь төслийн төлөвлөлт, дизайн, өөрчлөлт оруулахад хүргэдэггүй
+	Эерэг нөлөөлөл	Ийм нөлөөллийн дүнд эерэг үр дүнгүүд гардаг.

Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт. Дээрх хүснэгтээс үзэхэд байгалийн төрөл зүйлүүдээс зэрлэг ан амьтдын орон зайн өөрчлөлтөд нөлөөлөх нөлөөллийн зэрэг нь “бага”, харин агаар орчны бохирдол, газар доорх усны нөөцөд үзүүлэх нөлөөлөл бараг дундаас дээш зэрэгтэй байсан бол геологийн тогтцын өөрчлөлтөд хөрсний элэгдэл, эвдрэл ба бохирдол, ургамлын төрөл зүйлийн өөрчлөлт, усны чанарын өөрчлөлт зэрэг нөлөөлөл дунд зэрэг байхаар гарсан байна.

Байгалийн нөөцийн ашиглалт. Төслийн үйл ажиллагааны үед байгалийн нөөцөөс эрдэс түүхий эдийн нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөлөл “дунд зэрэг, бэлчээрийн болон газрын гадаргын нөөцийн ашиглалтад үзүүлэх нөлөөлөл “бага” байхаар гарч байна. Эрдэс түүхий эдийн нөөцөд нөлөөлөх сөрөг нөлөөлөл өндөр байгаа шалтгаан нь гаалийн хяналтын талбай нь олон жилийн туршид нүүрсийг ихээхэн хэмжээгээр экспортлохтой холбоотой.

Байгаль орчны чанар, нийгмийн өөрчлөлт. Хөрсний бохирдол, агаар орчны дуу чимээний физик бохирдол, ундны усны чанар хэмжээнд “дунд” зэргээр нөлөөтэй үнэлэгдэж байна. Энд орчны дэд бүтцийн хөгжил, орон нутгийн нийгэм эдийн засагт нөлөөлөх нөлөөллүүд эерэг үзүүлэлттэй байна.

Байгалийн цогцолборт газар, түүх соёлын дурсгалт зүйл, соёлт давхаргад үзүүлэх нөлөөлөл. Байгалийн үзэсгэлэнт төрх, орчны ландшафтын хэлбэр өнгө төрх, тусгай хамгаалалтай газарт үзүүлэх нөлөөлөл байхгүй.

Бусад нөлөөлөл. Автомашины зогсоолоос шалтгаалан хөрсний өнгөн хэсэг талхлагдах, ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржих болон байгалийн давагдашгүй хүчин зүйл /хүчтэй салхи, түймэр газар хөдлөл, аянга/-ийн нөлөөллийн зэрэг “бага” байхаар байна.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

БОМТ-ний Зорилго, зорилт

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангах, БОННУ-н дэх зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, төслийн үйл ажиллагаанаас үүсч буй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм. Тиймээс төслийн үйл ажиллагааны явцад үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитойгоор төлөвлөсөн БОМТ-г төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлөө бүрдүүлэх нь энэхүү төлөвлөгөөний үндсэн зорилго болно.

БОМТ үндсэн зорилгоо хангахын тулд төсөл хэрэгжүүлэгчийн санхүүгийн чадавхийн хүрээнд нийгмийн хариуцлагыг өндөржүүлэхэд чиглэсэн дараах бодлогыг баримтална. Үүнд:

- БОМТ-нд тусгасан ажлын дараалал, түүнийг хийж гүйцэтгэснээр хүрэх үр дүнг төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаа, санхүүгийн боломж нөөцтэй уялдуулах;
- БОМТ-ний хэрэгжилтийг компанийн удирдлага өөрөө болон орон нутгийн оршин суугчдын зүгээс хэрхэн хянаж, харилцан хамаарал бүхий бодит үр дүнд хүрэх;
- БОМТ-г зохих ёсоор хэрэгжүүлснээр гаалийн хяналтын талбайг хөндлөнгийн хяналт, шалгалтад бэлэн байлгах зэрэг нөхцөлүүдийг тодорхойлно.

БОМТ-ний гол зарчим

БОМТ-г боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх, тайлагнах үйл ажиллагаа нь БОАЖСайдын 2019 оны 10 сарын 29-ны өдөр баталсан А/618 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримтална.

БОМТ-ний хамрах хүрээ

БОМТ нь “Гаалийн хяналтын талбай” төслийн үйл ажиллагааны хэмжээнд дагаж мөрдөх эрх зүйн зохицуулалтын дагуу хэрэгжих бөгөөд БОННУ-ний тайлангийн 1 дүгээр бүлэгт төслийн хамрах хүрээг тодорхойлсон байгаа.

Төслийн бүтээн байгуулалт, үйл ажиллагааны явцад хүрээлэн буй орчныг хамгаалах, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилт бүхий энэ

төлөвлөгөөнд БОННУ-ний тайланд тусгасан зөвлөмжүүдийн хүрээн дэх бүхий л асуудлыг хамрахад БОМТ нь дараах үндсэн 2 хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх арга замууд, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа болон шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ),
- Төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдал, хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа орчны болон ажлын байрны нөхцлийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө зардал, хугацааг тусгасан орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ).

Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд баримтлах эрх зүйн баримт бичиг болон шаардлагыг нь зайлшгүй хангаж мөрдөх стандартуудыг БОМТ-нд тодорхой тусгаж өгнө.

Тухайн жилийн БОМТ боловсруулах, биелэлтийг тайлагнах журамд зааснаар байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь дараах агуулгатай байх бөгөөд хийх ажлын зардлыг тус бүрчлэн тооцож төлөвлөнө. Үүнд:

- Төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх арга замууд, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа болон шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан төлөвлөгөө;
- Орчны тохижилт, өргөтгөлийн дараах нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө;
- Төслийн талбай орчмын түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө;
- Үйл ажиллагааны үеийн осол, эрсдэлийн менежмент;
- Үйл ажиллагааны үеийн хог хаягдлын менежмент;
- Төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ;
- Тухайн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөлт;
- БОМТ-г нөлөөллийн бүсийн олон нийт, оршин суугчдад тайлагнах, хэлэлцүүлэх арга хэмжээний төлөвлөлт;

5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээ								
1.	Хорт хийн ялгарлаас агаарын бохирдол үүсэх	Төслийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгслүүдийг техникийн үзлэг, шалгалтад тогтмол оруулж, засвар үйлчилгээг тогтмол чанартай хийх	20	ш	-	4000.0	Жилд 1 удаа	- Байгаль хамгаалах тухай хууль - Агаарын тухай хууль - MNS 4585:2016 - Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 6.1-ийн 2
Газрын гадарга, хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө								
2.	Хөрсний элэгдэл, эвдрэл үүсэх	Талбайд болон ойр орчинд олон салаа зам гаргахгүй нэгдсэн маршрутаар явах, зам дагуу тэмдэг тэмдэглэгээг байршуулах	Төслийн талбай	3 ш	100,000	300.0	Зун	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
3.		Эзэмшил талбайн хашаа руу орох гарах хэсгийг цементлэн хатуу хучилттай болгох	50	м2		8000.0	3 улирал	
4.	Хөрс бохирдох, ургамлан нөмрөг талхлах	Авто машинуудын зогсоолын доорх талбайг хайрган хучилттай болгох	400	м2	800	5000.0	3 улирал	
		Зогсоолд байгаа автомашинуудын засвар, үйлчилгээг зөвхөн зориулалтын хатуу хучилттай талбайд хийх, доошоо тос, масло гоожиж хөрс бохирдуулахаас сэргийлэх	Засварын цэг	-	-	-	тогтмол	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль

Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө							
5.	Ургамлан нөмрөгийн талхагдал	Нөлөөлөлд өртсөн талбайн хөрсийг сийрүүлэн шимт хөрсөөр 5 см хүртэл зузаантай хучилт хийж ургамалжуулах, нөхөн сэргээх	Шаардлагатай тохиолдолд	м2	Ургамлан нөмрөг, хөрсөн бүрхэвч талхлагдсан тохиолдолд	тогтмол	MNS 5916:2023
НИЙТ ЗАРДАЛ			17,300.0				

6. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-ийн дагуу эзэмшил газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу зүлэгжүүлж мод тариалах шаардлагыг үүрэгжүүлж өгсөн байдаг. Иймд эзэмшил газрын 10-аас багагүй хувийг тохижилт, агаарын бохирдлыг бууруулах, ургамалжуулах зэрэг зорилгоор моджуулах арга хэмжээг зайлшгүй хийх шаардлагатай юм. “Гаалийн хяналтын талбай”-н ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан моджуулах ажлыг БОННУ-ний тайланд тусгасан зөвлөмжийн дагуу тарих шаардлагатай.

Ер нь газрын нөхөн сэргээлт гэдэг нь “эвдэрсэн газрын аж ахуйн үнэ цэнэ, бүтээмжийг нь сэргээх, тэрчлэн хүрээлэн буй орчны нөхцөлийг нийгмийн ашиг сонирхолд нийцүүлэн сайжруулахад чиглэсэн цогц арга хэмжээ” юм. Жил бүр мод тарих ажлыг зохион байгуулж, өмнө тарьсныгаа арчлах, амьдраагүй хэсэгт нөхөн тарилт хийх зэргээр уламжлалт тогтсон өдөртэй болох шаардлагатай.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд жилд 1000ш мод тарих мөнгийг орон нутгийн тусгай дансанд байршуулна.

Хүснэгт 3. Нөхөн сэргээлт, орчны тохижилтын төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж, ш	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Кемпийн хашааны баруун болон хойд талаар мод бут тарьж хашаалах, салхины хаалт хийх	Жигд /3 нас/	Төслийн талбай	50	15,000	750,0	5, 10 сард	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ Ерөнхийлөгчийн санаачилга
		Сухай /3нас/		50	15,000	750,0		
		Хайлаас /3нас/ тарьц авах		100	9,000	900,0		
2		Суулгацыг суулгах	Төслийн талбай	0.12 га	60.0	36,0	5, 10 сард	
3	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих	Орон нутгийн тусгай дансанд байршуулах		1000 шир	11,250	11,250.0	Хавар, намар	
Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн нийт зардал, мян.төг						13,686.0		

7. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Төслийг хэрэгжүүлэх хугацаанд болон цаашид ойролцоох аж ахуйн нэгж, иргэдэд нүүлгэн шилжүүлэх шаардлага өгөөгүй учир нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ өнөөгийн төслийн хүчин чадал, техник эдийн засгийн үндэслэлийн үед гарахгүй.

8. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн талбай болон түүний орчмын нутагт нь түүх соёлын дурсгалд тооцож болохуйц газар болон археологийн болон палеонтологийн олдвор одоогоор тохиолдоогүй.

Цаашид үйл ажиллагааны явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрсэн үед “Монгол Улсын Үндсэн хууль”-ийн I бүлгийн 7-р зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж заасны дагуу түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбоотой үүрэг хариуцлагаа мөрдөж ажиллах нь зүйтэй.

Соёлын ба үнэт өв зүйлсийг илрүүлж, тэр нь төслийн үйл ажиллагаанд эрсдэхээр байвал орон нутгийн засаг даргаас энэ үйл ажиллагааг даруй зогсоохыг шаардах, бололцоотой бол эдгээр газруудыг аль болох зохистойгоор хамгаалахыг хуульд заасан байдаг. Боловсрол, Соёл, ШУ-ны яамны тусгай зөвшөөрөлгүйгээр зөөж шилжүүлэх боломжгүй соёлын ба үнэт дурсгалын өвийг малтах, зөөх, эвдэхийг хуулиар хориглосон.

Хүснэгт 4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Төслийн ажиллагааг аар	Соёлын өвийг хамгаалах тухай МУ-ын хуулийн дагуу газрын хэвлийг ашиглах явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл олборлох ажлаа зогсоож энэ тухай, аймгийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх	Жил бүр	Бүтээн байгуулалт, үйл ажиллагаанд нэмэлтээр тусгах		Тухайн үед нь шийдэх	Соёлын өвийг хамгаалах тухай хууль

9. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагаанд ахуйн угаалгын (саван, шампунь, угаалгын нунтаг) бодисоос өөр химийн болон цацраг идэвхт бодис хэрэглэгдэхгүй. Тиймээс ахуйн угаалгын бодисоо зориулалтын газар хадгалж хог хаягдлыг зохих журмын дагуу зайлуулах шаардлагатай.

Осол эрсдэлээс хамгаалах ажлын ихэнх нь төслийн үйл ажиллагааны явцад хөдөлмөрийн сахилга бат, хариуцлагын тогтолцоогоор шийдвэрлэгдэх боломжтой бөгөөд цаг уурын эрсдэлтэй нөхцөлөөс үүсэх гэнэтийн осол, цаашлаад зэрлэг ан амьтдын ослоос урьдчилан сэргийлэх ажилд холбогдох зардал нь төслийн үйл ажиллагааны зардлын санхүүжилтийн хүрээнд шийдвэрлэгдэх боломжтой юм.

Хүснэгт 5. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	Осол аваар гарч хүний эрүүл мэнд, нас хохирох	Анхан шатны түргэн тусламжийн хайрцгийг шаардлагатай газруудад бэлэн байлгах	5ш	-	200.0	Улирал бүр шалгах	Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль
2		Кемпэд байгаа ажилчдын бие муудсан тохиолдол, осол аваар гарсан үед даруй анхан шатны тусламж үзүүлэх, шаардлагатай бол хамгийн ойрын эмнэлэгт хүргэж өгөх	-	-	-	Тухайн тохиолдолд	Эрүүл мэндийн тухай хууль
3	Галын аюулаас эд материал, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулан холбогдох байгууллагаас зөвлөгөө аван батлуулах	1 ш	-	-	3-р улирал	Гамшгаас хамгаалах тухай хууль
4		Гал унтраах хэрэгслийг бэлэн байлгах, галын хорны ажиллагааг шалгаж, цэнэглэх	-	-	-	Тогтмол	Галын аюулгүй байдлын тухай хууль

5	Санамсар болгоомжгүй үйлдлээс байгаль орчинд сөргөөр нөлөөлөх	Бүх ажилчдад байгаль хамгаалах, хог хаягдлыг ангилан ялгах, осол аваараас хэрхэн урьдчилан талаар сургалт орох	жилд 2 удаа	-	-	Улирал бүр	Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль Галын аюулгүй байдлын тухай хууль Байгаль орчныг хамгаалах тухай хууль
6	Амралтын байр, гэрт байгаа ажилчдын бие муудах	Хүний эрүүл мэнд муудахад харьяа сумын эрүүл мэндийн нэгдсэн төвд хүргэх арга хэмжээг авна.	Хүний бие муудсан тохиолдолд	-	-	Тухайн үед нь	Галын аюулгүй байдлын тухай хууль Байгаль орчныг хамгаалах тухай хууль
7	Байгалийн болон хүний хүчин зүйл, үйл ажиллагааны доголдлоос гал гарах	Галын аюулаас урьдчилан сэргийлэх, гал гарсан үед авах арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	1 удаа	-	200.0	Үйлдвэрийн үйл ажиллагаа эхлэх үед	Галын аюулгүй байдлын тухай хууль
8	Үерийн улмаас ажилчдын байр усанд автах	Эзэмшил талбайн хашааг тойруулан үерээс хамгаалах суваг, шуудуу татах	500м	-	Өөрийн техникэ эр	5 сард	
Нийт, мян.төг					400.0		

10. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Үйл ажиллагааны үед гарсан хог хаягдлыг байгаль орчинд бохирдол багатайгаар зайлуулах, ангилан ялгах дахин ашиглах асуудлыг зохицуулахад менежментийн төлөвлөгөөний зорилго оршино. Ажилчдын суурингаас ахуйн лонх, лааз, цаас, хоолны үлдэгдэл, бусад гэсэн байдлаар нь ангилан хадгалж дахин ашиглагдах хэсгийг нь хоёрдогч түүхий эдийн цэгт нийлүүлэн, үлдэх буюу ашиглагдахгүй хэсгийг хогийн цэгт зайлуулах нь зүйтэй.

Хог хаягдлын менежментийн цар хүрээ

Баримтлах зарчим. Төслийн үйл ажиллагааны явцад “Хог хаягдлын менежмент”-боловсруулах нь хэрэгжүүлэх бөгөөд энэ нь дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Хог хаягдлын тухай Үндэсний болон Олон Улсын нийтлэг хууль, журмыг дагаж мөрдөхөд нийцсэн орчин бүрдүүлнэ.
- Хог хаягдлын менежментийн хүрээнд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас болон 2019 оны 5 сарын 07-ны өдрийн “Хог хаягдлын менежмент” Үндэсний чуулганаас гаргасан зөвлөмжийг дагаж мөрдөнө.

Хог хаягдлыг ангилах. Төслийн үйл ажиллагаанаас дараах төрлийн хог хаягдлууд гардаг бөгөөд одоогийн байдлаар “Хог хаягдлын менежмент”-ийн зураг авалт хийж тоо хэмжээг тодорхойлсон зүйлгүй байна.



Зураг 1. Хог хаягдлын аюулын зэрэглэл, ангилал

Хог хаягдлыг түр хадгалах. Төслийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ангилах, өөр дээр түр хадгалахад “Хог хаягдлын тухай” хуульд заасан шаардлагад нийцүүлэх бөгөөд хуулийн 7 дугаар бүлгийн 14 дүгээр зүйлд заасан “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх” болон Засгийн газрын 2018 оны 116 тоот тогтоол, “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам”-ын хүрээнд хэрэгжүүлнэ.

Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх

Төслөөс гарах хог хаягдлын төрлүүд ба хэмжээ: Төслийн хүрээнд дараах хог хаягдалд энгийн болон аюултай хог хаягдлын төрлүүд гарахаар байна. Хог хаягдлын гарцын хэмжээг төсөл хэрэгжүүлэгч хог хаягдлын нэр төрөл бүрээр нь холбогдох эх үүсвэр дээр нь ажлын зураг авалт хийж норматив тогтоох шаардлага тавигдаж байгаа. Бид БОМТ-ний хүрээнд төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг ажиллах хүч, ажлын хоног, хэрэглээний норм, техникийн ээлж гэх зэрэг үзүүлэлтүүдэд үндэслэн дараах байдлаар тооцлоо.

Хүснэгт 6. Төслийн үйл ажиллагааны явцад гарах хог хаягдлын хэмжээ

Хог хаягдлын ангилал	Хог хаягдлын нэр төрөл	Хог хаягдлын хэмжээ
Энгийн хог хаягдал		
Дахин ашиглах боломжтой	Цаас	6 ажилтан сард 0.2кг/хүн бичиг цаасны хаягдал
	Шил	Хүнсний баглаа боодлоос 30хүн/хон*0.6 =18.0 кг
	Хуванцар,	Хүнсний болон ахуйн хэрэглээнээс 30 хүн/хон*0.5=15 кг
	Резин	Техникийн ээлжийн тоогоор тооцно.
	металл, төмөр	Нийт үүсэх хэмжээнээс: <ul style="list-style-type: none"> Ундааны сав баглаанаас 30 хүн/хон* 0.3= 9кг Техник тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнээс гарах металлыг тооцоолох боломжгүй байна
Хүнсний хог хаягдал	(гал тогооны хаягдал)	30 хүн*0.1кг = 3кг
Бусад хаягдал	Хэтэрхий бохирдсон ашиглах боломжгүй хог хаягдал	Нийт ажиллагсдын хэрэглээнээс 30 хүн*0.15кг=4.5кг
	Ахуйн хэрэглээнээс гарсан дахин ашиглахгүй шингэн хаягдал	Төслийн хүрээнд унд ахуйд ашиглах усны 90 хувь нь ахуйн бохир болж хаягдана.
Аюултай хог хаягдал		
Батарей аккумулятор	Хар тугалгатай батарей	Техникийн ээлжийн тоогоор 5 жилийн хугацаанд 16тн гарна.
Хаягдал тос ба шингэн түлш	Түлшний тос, дизель	Төслийн талбайд одоогийн байдлаар 100 машин байрладаг ба жилд машин техникээс гарах шингэн хаягдал нь 5700л байна
Шингэн хадгалах танк, зөөврийн танк, торхны цэвэрлэгээний хаягдал	Тос агуулсан хаягдал	Тос агуулсан хаягдал нь: <ul style="list-style-type: none"> Тос агуулсан арчих материалын хаягдал Тос агуулсан хөрсний хуулдас
	Хаягдал шингэн катализатор	Тооцох боломжгүй. Катализатор үүсэх нөхцөл үгүй гэж үзнэ. Аккумуляторыг холбогдох үйлчилгээ үзүүлдэг газарт цэнэглэнэ.

Хог хаягдлын ангилал. Төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг дээр заасан байдлаар ангилах бөгөөд тэдгээрт нийцсэн арга хэмжээг хэрэгжүүлж төслийн талбайн орчинд хог хаягдлыг ангилах, ангилсан хог хаягдлыг төвөг багатайгаар цуглуулах тухай мэдээллийг үйлчлүүлэгч олон нийтэд мэдээлж сурталчлахын зэрэгцээ хогийн цэгүүдийг оновчтой байршуулж холбогдох тэмдэг, тэмдэглэгээг ойлгомжтойгоор хийнэ.

Хүснэгт 7. Төслийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлын ангилал

№	Менежментийн ангилал	Талбайд үүсэх хог хаягдал	Хог хаягдлыг зайлуулах
1	Дахивар хаягдал	хүнсний болон бүх төрлийн шилэн сав, шилэн эдлэл	Дахивар хог хаягдал хүлээн авагчидтай гэрээ хийж хоёрдогч зах зээлд нийлүүлнэ. Гэрээнд ангилсан хог хаягдлын шаардлагад хэрхэн нийцүүлэх тухай асуудлыг тусгана.
		Хөнгөн цагаан, төмөр, металл, зэс, гууль, тэдгээрээр хийсэн зүйл	
		Элдэв зөөлөн хуванцар, гялгар уут, гялгар баглаа боодол	
		Хувцас, даавуун эдлэл	
		Савхи, резин, мод зэрэг дахин ашиглах боломжит бусад хаягдал	
2	Цаасны хаягдал	сонин, сэтгүүл, дэвтэр	
		бичгийн цаас	
		төрөл бүрийн боодлын цаас, картон	
		сүү, жүүсний тетрапак савлагаа	
3	Хүнсний хаягдал	Нийтийн хоолны үлдэгдэл	Хог хаягдлыг устгах сумын нэгдсэн цэгт нийлүүлэх гэрээ хийж ачилтын хуваарийг тохирно.
		Хүнсний ногоо, жимсний хальс, үлдэгдэл	
		Хэрэглэсэн хүнсний тос	
4	Аюултай хаягдал	Халаалтын болон уурын зуухны үнс,	Хог хаягдлын тухай хуулийн 8-р зүйлийн 8.4.3-т заасны дагуу харьяа нутаг дэвсгэрийн эрх бүхий аж ахуй нэгжтэй гэрээгээр зайлуулна.
		Принтерийн хор, батарей, аккумулятор зэрэг ашиглалтаас хаягдаж буй техникийн аюултай хаягдал	
5	Бусад хаягдал	Хэт бохирдсон дахин ашиглах боломжгүй хог хаягдалд: <ul style="list-style-type: none"> Нийтийн ариун цэврийн өрөөний хаягдал Мөн ангилаагүй норсон, хэт бохирдсон хаягдлууд орно. 	Септик систем суурилуулна
		Хийн хаягдал: <ul style="list-style-type: none"> Машины ашиглалтаас үүсэх хий 	Авто машины үзлэг оношилгоо, янданд шүүлтүүр тавих



Хаягдал цуглуулах сав

- Хог хаягдлыг зайлуулах хүртэл түр хадгалах нөхцөлийг сайжруулах: Төслийн үйл ажиллагаанаас гарч байгаа хог хаягдлыг дараах эрэмбээр түр хадгална. Үүнд: Үүссэн хог хаягдлыг “Хогийн төвлөрсөн цэг”-т хүртэл эх үүсвэр дээр нь цуглуулж маш богино хугацаагаар хадгална. Эх үүсвэр хаягдал цуглуулах ажиллагаа нь нийтийн үйлчилгээний үед хаягдлыг ангилсан хэлбэрээр цуглуулах нөхцөлд нийцсэн байна.
- Хог хаягдлыг “Хогийн төвлөрсөн цэг” нь ангилсан байдлаар түр хадгалах бөгөөд тэдгээрийг эрх бүхий этгээдэд шилжүүлэх хүртэл хадгална.
- Түр хугацаагаар хадгалах “Хогийн төвлөрсөн цэг” нь элдэв үнэр гаргахгүй, хог хаягдлыг норгохгүй, хийсгэхгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Хүснэгт 8. Хог хаягдлыг цуглуулах, түр хадгалах нөхцөлийг сайжруулах

Нөхцөл	Шаардлага
Эх үүсвэр дээр нь хог хаягдлыг ангилах	<ul style="list-style-type: none"> • Нийтийн үйлчилгээний зам талбайд хог хаягдлыг цэвэрлэж цуглуулахад ангилах боломжит нөхцөлийг бүрдүүлэхэд хог хаягдлын ангиллын олон улсын нийтлэг жишгийг дагана. • Дахин ашиглахгүй бохир хаягдал, хүнсний хаягдлын түр хадгалалт хугацаа болон эргэлтийн хугацааг хамгийн богино байх шийдлийг боловсруулна. • Нүхэн жорлонг байлгах шаардлагатай бол MNS 5924:2015 “Нүхэн жорлон угаадасны нүх. Техникийн шаардлага”-ын стандартад нийцүүлэн шинэчилнэ. • Аюултай хог хаягдлыг цуглуулах, түр хадгалах, зайлуулах менежментийг тусгайлан боловсруулна. • Ангилсан хог хаягдлыг дахин боловсруулах, устгах, эргэлтэд оруулах нөхцөлөөр нь ялган тус тусад нь “эрх бүхий этгээд”-д гэрээний үндсэн дээр шилжүүлэн өгнө.
Цуглуулсан хог хаягдлыг зайлуулах	<ul style="list-style-type: none"> • Нийтийн үйлчилгээний зам талбай ажилчид нарт хог хаягдлын менежментийн шаардлага тавьж, тэдгээрийн орчинд үүссэн хог хаягдлыг “Төвлөрсөн хогийн цэг”- хүлээн авна. • Ажлын байрны хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилах нөхцөлийг бүрдүүлж ажиллагсад “Хог хаягдлын менежмент”-ийг таниулан, ангилсан хог хаягдлыг цэгүүдийн байршлыг зааж, тэмдэгжүүлнэ. • Ангилсан хаягдал бүрийг тусгайлан түр хадгалахад эрх бүхий этгээдэд шилжүүлэх хүртэлх эргэлтийн циклийг тооцно. • Хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, түр хадгалах, зайлуулах

	<p>явцад ажлын зураг авалт хийж ангилсан нэр төрөл бүрээр тоо хэмжээг тодорхойлно.</p> <ul style="list-style-type: none"> Ил задгай хаягдаж байгаа цэгүүдийн байршлыг хугацаа алдахгүй тогтоож шаардлагатай сав бэлдэх, байршуулах, тэмдэгжүүлэх зэрэг арга хэмжээг хурдан шуурхай авна.
Хог хаягдлын боловсролыг дэмжих	<ul style="list-style-type: none"> Нийтийн үйлчилгээний цэгээс хог хаягдлыг ангилсан хэлбэрээр цуглуулахад тэмдэгжүүлэлт, мэдээлэл, зар сурталчилгааг оновчтой зөв хэрэглэнэ. Ил задгай хог хаягдал хаях явдлыг бууруулахад чиглэсэн торгууль шийтгэл оногдуулах, мэдээлэл хүлээн авах, урамшууллын систем бүхий олон нийт рүү чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ. Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхэд ажиглан-туслах, хянан-шаардах арга хэмжээг хэрэгжүүлэх үүргийг холбогдох ажилтанд давхар үүрэгжүүлнэ. Шаардлагатай гэж үзвэл нийтийн үйлчилгээний заал, танхимд ажиглан-туслах, хянан-шаардах арга хэмжээг хэрэгжүүлэх сургагч, ажилтныг тодорхой хугацаагаар ажиллуулна.

Хог хаягдлыг зайлуулах, устгах. “Хог хаягдлын тухай” хуулийн шинэчлэлийн дагуу хог хаягдлыг цуглуулах, зайлуулах, устгах харилцааг зохицуулах зөвлөмжийг төслийн хүрээнд үүсэх хог хаягдлын нэр төрөл бүрээр авч үзэх шаардлагатай болно. Үүссэн хог хаягдлын хэмжээ нэр төрлүүдээр нь эрх бүхий этгээдэд шилжүүлэн зөвшөөрөгдсөн цэгт нийлүүлнэ.

Хүснэгт 9. Хог хаягдлыг зайлуулах

Хог хаягдлын нэр төрөл	Хог хаягдлын хэмжээ
Энгийн хог хаягдал	
цаас	Дахин боловсруулах боломжтой тул эрх бүхий этгээдэд хүлээлгэн өгөхийн тулд гэрээ хийнэ. Түр хадгалалтын цэгийг хуримтлагдах хэмжээ, тээвэрлэлтийн хугацаатайгаа уялдуулан төлөвлөсөн байна.
шил	
хуванцар, резин,	
металл, төмөр	
Хүнсний хаягдал, (гал тогооны хаягдал) Хэтэрхий бохирдсон	Маш бага хэмжээтэй гарах бөгөөд хэт бохирдолтой, удаан хугацаагаар хадгалах боломжгүй хаягдал тул хамгийн цөөндөө 7 хоногт 2 удаа зайлуулна. Тиймээс эрх бүхий этгээдээр тогтоосон хугацаанд

ашиглах боломжгүй хог хаягдал	тээвэрлүүлэн зөвшөөрөгдсөн цэгт хүргүүлнэ.
Ахуйн хэрэглээнээс гарсан шингэн хаягдал	Цэвэрлэх байгууламжид төвлөрнө.

Хүснэгт 10. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.		Хуурай хог хаягдлыг зориулалтын бус зууханд шатаах, газар булахыг хориглоно. Боломжтойг хаягдал боловсруулах газарт өгөх, дахин ашиглах, үлдсэн хог хаягдлыг зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагад нийлүүлнэ.	Төслөөс гарах хог хаягдал	ш		-		Тогтмол	“Хог хаягдлын тухай” хууль, “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага”, “Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам”
2.	Ахуйн	Үйл ажиллагаанаас гарсан хогийг ангилан ялгуулж байх, ажилчдад хог хаягдлаа ангилан хаях талаар мэдээлэл сурталчилгаа хийх, хогийн савнуудыг тэмдэгжүүлэх	Төслийн үйл ажиллагаанаас гарах бүх хог хаягдал	-	-	-	-	Тогтмол	
		Хуванцар сав, шил, лааз, гялгар уут, цаас гэх мэт дахин боловсруулах хог хаягдлыг 2-догч түүхий эд авах цэгт тушаах, үлдсэн хог хаягдлыг нутгийн мэргэжлийн байгууллагад нийлүүлэх	кемп, авто зогсоолоос гарах бүхий л хог хаягдал	-	-	-	-	Сар бүр	
		Бохирын цооногийг соруулж хаягдал бохир ус цэвэрлэх байгууламжид нийлүүлэх	Кемпээс гарах хаягдал бохир шингэн хаягдал	м3	-	-	Гэрээ байгуулах	Бохирын цооногийн 70% дүүрсэн тохиолдолд	

3.	Аюултай	Зогсоолд байрлах автомашинуудын засвар үйлчилгээнээс шатах тослох материал, тостой даавуу гэх мэт аюултай хог хаягдал гарвал мэргэжлийн байгууллагад нийлүүлэх	Аюултай хог хаягдал үүсэх эх үүсвэрүүд	тн	-	-	Мэргэжлийн байгууллага тай гэрээлэх	Жил бүр
		Ашигласан хаягдал аккумуляторыг хаягдал аккумулятор боловсруулах тусгай зөвшөөрөлтэй байгууллагад нийлүүлэх	Автомашин засвараас гарсан	ш	-	-	Мэргэжлийн байгууллага д нийлүүлэх	Жил бүр
		Хаягдал баттерейг Цэнгэг усны төвд тушаах	Үйл ажиллагаанаас гарах	ш	-	-	-	Улиралд 1 удаа
4.	Түр хадгалах	Хог хаягдлыг ангилан ялгах, түр хадгалах төвлөрсөн хогийн цэг байгуулах	Талбайн хэмжээнд	ш	300	1	300.0	2 улирал
5.	Ариутгал, халдваргүйжүүлэлт хийх	Хатуу шингэн хог хаягдлын цэгүүдэд ариутгал, халдваргүйжүүлэлт хийх	Хог хаягдлын цэг	Удаа	20,000	Сард 1 /жилд 12 удаа/	12 сар*20 = 240.0	сар бүр
6.	Хог хаягдал зайлуулах	Хогийг хог хаягдал эрх бүхий мэргэжлийн байгууллагад шилжүүлэх	Талбайн хэмжээнд	удаа	40,000	Сард 2 /жилд 24 удаа/	12 сар*40 = 480.0	сар бүр
Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх нийт зардал, мян.төг								1,020.0

11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Төслийн үйл ажиллагаанаас үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” гэнэ.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр нь “Гаалийн хяналтын талбай байгуулах” төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд гарч байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлох, болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилготой.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт дараах зүйлсийг тусгасан байх болно. Үүнд:

- Байгаль орчны бүрэлдэхүүн тус бүрт үзүүлэх нөлөөлөл;
- Хяналт-шинжилгээ явуулах зайлшгүй шаардлагатай үзүүлэлтүүд;
- Хяналт-шинжилгээ явуулах төрөл, хэлбэр;
- Хяналт-шинжилгээ хийх, сорьц авах цэгийн байршил;
- Хяналт-шинжилгээ явуулах хугацаа, давтамж;
- Хяналт-шинжилгээ явуулах арга, аргачлал;
- Хяналт-шинжилгээ явуулахад шаардлагатай техник, тоног төхөөрөмж;
- Хяналт-шинжилгээний үр дүнг нэгтгэх, тайлагнах арга, хэлбэр зэрэг болно.

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төслийг хэрэгжүүлэх явцад үүссэн сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа болон нутгийн оршин суугчдад бодит мэдээлэл өгөхөд чухал ач холбогдолтой.

Энэхүү орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг боловсруулахдаа 2019 оны БОАЖЯ-ны сайдын А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг удирдлага болгов.

Хүснэгт 11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамж ийн тоо	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга аргачлал
Агаар								
1	- PM _{2.5} , PM ₁₀ - SO _x - NO _x - CO _x - Дуу шуугиан	- Ажилчдын гэр, байр - Гал тогоо - Эзэмшил талбайн хашаа	2, 3-р улиралд	Жилд 2 удаа	150.0	300.0	БОХЗТЛаб, МУИС-ын Цөмийн судалгааны төв	Агаарын тухай хууль MNS 4585:2016 MNS 5885:2019
Хөрс								
2	- Агрохими - Хүнд металл	- Хогийн цэг - Нүхэн жорлон - Авто зогсоол	2, 3-р улиралд	Жилд 2 удаа	110.0	220.0	ГГХ, Хувийн лабораториуд	MNS 5850:2019
	- Бактереологи	- Хогийн цэг	3-р улиралд	Жилд 1 удаа	70.0	70.0	“Ханлаб” ХХК, НЭМҮТ	MNS 5850:2019
Ус								
3	- Анион, катион - Хүнд металл - Бактереологи	- Хэрэглээний усаа зөөврөөр хангадаг малчны гар худаг	3-р улиралд	Жилд 1 удаа	150.0	150.0	Газарзүй-геозкологи, Монгол Ус ТӨҮГ-ын Усны лаборатори	MNS 900:2018 MNS 4943:2015 MNS 6148:2010 Усны тухай хууль
	Нийт зардал, мян.төг					740.0		

12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилсан төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
1	Галба-Өөш, Долоодын говийн сав газраар “Хаягдал усны дүгнэлт” гаргуулах	50.0	2 улирал	Захирал, Менежер	Усны тухай хууль
2	Сумын Засаг даргатай “Хаягдал усны гэрээ” байгуулах	-	2 улирал	Менежер	Усны тухай хууль
3	Байгаль орчны аудит хийлгэх	Мэргэжлийн байгууллагатай харилцан тохиролцоно	2-3 улирал	Захирал	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
	Нийт зардал, мян.төг	50.0			

13. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах

№	Зардлын агуулга	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Хариуцах албан тушаалтан	Холбогдох зардал	Зохион байгуулах газар
1	БОМТ-ний биелэлтийн тайлан	Цахим тайлан	Төлөвлөгөөт ажлын тайлан, биелэлтийн	Жил бүрийн 10 сарын 15-ны дотор	Мэргэжилтэн	Үйл ажиллагааны зардлаар	“Кайтл районч” ХХК-ийн байр
2	Орон нутгийн удирдлага, хөндлөнгийн хяналт, олон нийтийн оролцоо	Хэвлэмэл болон цахим тайлан	ҮР ҮР ДҮН, дараа жилийн БОМТ	Жил бүрийн 11 сарын 01-ний дотор	хариуцсан мэргэжилтэн	250.0	сумын нутгийн удирдлагын ордон
БОМТ-г тайлагнах ажлын зардлын дүн, мян.төг					150.0		

Хүснэгт 12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх зардал

БОМТ-ний хүрээнд хийх ажлын багц	Нийт тооцсон зардал, мян.төг
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	17,300.0
Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	13,686.0
Осол эрсдэлээс хамгаалах төлөвлөгөө	400.0
Хог хаягдлын менежментийг зохион байгуулах	1,020.0
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	740.0
Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ	50.0
БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх	150.0
Нийт зардал	33,346.0

Өмнөговь аймгийн Ханбогд суманд орших Гаалийн хяналтын талбайн “ажилчдын кемп, авто зогсоол” төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал 33,346.0 мян.төг болно.